



## АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 6/81

Улаанбаатар хот

### Ц.Шийлэгбатад ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 47.1.1, 47.2, 48.1.3, 48.3, 48.8, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.5, Захиргааны ерөнхий хуулийн 26.1, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”, Архивын ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.1, 5.2.6, 5.5.1, 6.3.10, 8.10, 8.12, 9.4, 13.1, 13.2, 13.3, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2019 оны 06 сарын 19-ний өдрийн 690 тоот албан бичиг, Цэрэннадмидын Шийлэгбатын 2019 оны 05, 06 сарын ажлын цаг ашиглалтын мэдээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Шийлэгбат нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2019 оны 05 сарын 20-ны өдрөөс 2019 оны 06 сарын 24-ний өдрийн ажлыг тасалж, төрийн жинхэнэ албан хаагчийн хуулиар хүлээсэн үүрэг, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг ноцтой зөрчсөн тул түүнийг 2019 оны 06 сарын 24-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь халсугай.

2. Ц.Шийлэгбаттай санхүү аж ахуйн болон бусад төлбөр тооцоог хийж дуусган, ажлыг зохих журмын дагуу хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч:

Б.Цэвэлмаа  
(Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга)

Комиссын гишүүд:

Э.Дөлгөөн  
(Санхүү, аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн)

С.Лхамсүрэн  
(Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын  
хэлтсийн мэргэжилтэн)

3. Ц.Шийлэгбатын ажлыг 2019 оны 06 сарын 28-ны дотор зохих журмын дагуу хүлээн авахыг комисс /Б.Цэвэлмаа/-т даалгасугай.

Tushaal

368110455

4. Албан хаагч нь сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад, эсхүл шүүхэд гаргаж болохыг дурдсугай.

5. Энэ тушаалын хувийг журмын дагуу Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх арга хэмжээ авахыг Захиргааны удирдлагын газар /Л.Уянга/-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.ЭНХБААТАР